

Дорноговь аймаг дахь сум дундын Иргэний хэргийн

анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргах нь

**...оны...сарын...ны өдөр
Сайншанд сум**

**Нэхэмжлэгч: Боржигон овогт С.С, Дорноговь аймгийн Сайхандулаан сумын
...баг....гудамж ... байр ... тоот,Утас xxxxxxxx**

Нэхэмжлэлийн шаардлага: Хамтын амьдралтай байсныг тогтоолгох тухай

Нэхэмжлэлийн үндэслэл: Би Ц.Э-тэй 1996 он 09 сарын 20-ны өдөр танилцаж, 1997 оны 01 дүгээрсарын 25-ны өдрөөс хамтран амьдарч эхлэсэн. 2005 оны 07 дугаар сарын 01-ний өдөр охин Э.Н-ийг төрүүлсэн юм. Тэр цагаас хойш бид хоёр нэг гэрт хамтран амьдарч байгаад Ц,Э маань 2007 оны 9-р сард БНСУ-ын Сүүл хотын Пусаны их сургуульд суралцахаар явж, тэнд суралцаж байгаад 2008 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр ослоор нас барсан.Бид хоёр энэ хугацаанд хадам аав Л.Ц-ийн хамт Дорноговь аймгийн Сайншанд сум 6-р баг, ... байрны тоотод амьдарч байсан. Хоёулаа сургуулиа төгсөж ирээд гэрлэлтээ батлуулах бодолтой байсан. Охин Э.Н-д тэжээгчээ алдсаны тэтгэмж тогтоолгох болсон тул бид хоёрыг 1997 оны 01 дүгээр сараас, 2008 оны 04 дүгээр сарыг хүртэл хамтран амьдарч байсныг тогтоож өгнө үү.

Нэхэмжлэл гаргасан:/ гарын үсэг / С.С

Нэхэмжлэлд хавсаргасан материал:

1. Нэхэмжлэл 1 хувь
2. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт
3. Нас барсаны гэрчилгээний хуулбар / нотариатаар гэрчлүүлсэн/
4. Иргэний үнэмлэхийн хуулбар / нотариатаар гэрчлүүлсэн/
5. Багийн засаг даргын тодорхойлолт
6. Хүүхдүүдийн төрсний гэрчилгээний хуулбар / нотариатаар гэрчлүүлсэн/
7. Гэрчийн тодорхойлолт / 2 хүний /
8. Тодорхойлолт гаргасан 2 хүний иргэний үнэмлэхийн хуулбар/ нотариатаар гэрчлүүлсэн/

Улсын тэмдэгтийн хураамж төлөхдөө шүүхэд хандах болон Дорноговь аймгийн Татварын газарт хандан төлбөрийн даалгавар үүсгүүлж хураамжаа банкинд тушаана.

Шүүхийн утас: 70522144, 92172020

Анхаарах: /Та цаасны зүүн захаас 30 мм, дээд, доод захаас 20мм, баруун захаас 15 мм зайтай бичнэ/ /Нотлох баримтыг эх хувиар нь өгөх боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг гаргаж өгнө